ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Биг Могул ББСБ" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УЛААНБААТАР ХОТ, 2025 ОН

"ИНТЕР АУДИТ" ХХК



АГУУЛГА

I. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

II. ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

III. 2024 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

IV. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

№ 51 огноо 2025.1.30

“Биг Могул ББСБ” ХХК-ИЙН МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН НЭР:	Биг Могул ББСБ ХХК
РЕГИСТРИЙН ДУГААР:	5934915
КОМПАНИЙН УДИРДЛАГА:	Б.Манлай
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:	Б.Батмөнх /100%/
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:	Зээл олгох үйл ажиллагаа
КОМПАНИЙН ХАЯГ:	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-хороо, Цэнтрум төв, 401 тоот
ХОЛБОО БАРИХ:	80045095

АУДИТЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

АУДИТОР, МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИД,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ч.МӨНХБАЯР

Аудитын компанийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр, 802 тоот

Холбогдох:

Утас: 99004839
Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

1

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Биг Могул ББСБ" ХХК-ИЙН УДИРДЛАГАД

ДҮГНЭЛТ

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Биг Могул ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн санхүүгийн тайланд аудит хийлээ. Бидний үзэж буй "Биг Могул ББСБ" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартындагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэгтэй бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаагаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу зогсолтгүйүйл ажиллагаа явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ХҮЛЭЭХ АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж, аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

1. Залилан эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай ба зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүйбайх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

2. Байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоодхяналтын талаар ойлголт олж авдаг.

3. Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.

4. Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал байгууллага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

5. Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Хүндэтгэсэн,

"ИНТЕР АУДИТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.МӨНХБАЯР

Тайлангийн огноо: 2025/01/30

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2

АУДИТ ХИЙСЭН ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
А. ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ		
1. Мөнгөн хөрөнгө	63,370,958.40	701,585,908.29
2. Зээл /цэвэр/	577,367,548.27	2,971,665,441.86
3. Хөрөнгө оруулалт	-	-
4. Бусад санхүүгийн хөрөнгө	2,485,829,170.43	40,684,109.80
Санхүүгийн хөрөнгийн дүн	**3,126,567,677.10**	**3,713,935,459.95**
5. Үндсэн хөрөнгө	6,342,041.52	15,499,048.79
6. Биет бус хөрөнгө	3,696,000.00	3,696,000.00
7. Бусад санхүүгийн бус хөрөнгө	-	7,000,000.00
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**10,038,041.52**	**26,195,048.79**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,136,605,718.62	3,740,130,508.74
1. Санхүүгийн өр төлбөрийн дүн	-	101,469,724.22
2. Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	113,270,808.94	82,752,136.17
Өр төлбөрийн дүн	**113,270,808.94**	**184,221,860.39**
3. Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,500,000,000.00	2,500,000,000.00
4. Өмчийн бусад хэсэг	-	-
5. Хуримтлагдсан ашиг	523,334,909.68	1,055,908,648.35
Эзэмшигчийн өмчийн дүн	**3,032,334,909.68**	**3,555,908,648.35**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,136,605,718.62	3,740,130,508.74
Б. ОРЛОГЫН ТАЙЛАН		
1. Хүүгийн орлого	884,872,080.56	581,541,124.01
2. Хүүгийн зардал	37,229,447.87	-
Цэвэр хүүгийн орлого	**847,642,632.69**	**581,541,124.01**
Эрсдлийн сангийн зардал	(321,221,681.09)	(18,900,000.00)
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	**526,420,951.60**	**562,641,124.01**
3. Бусад орлого	219,112,678.93	340,144,978.31
4. Бусад зардал	-	278,979,789.07
Татварын өмнөх ашиг /алдагдал/	**307,308,272.67**	**623,806,313.25**
Орлогын албан татварын зардал	30,943,786.88	64,513,981.12
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	276,364,485.79	559,292,332.13
В. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН		
1. Эхний үлдэгдэл	2,814,970,423.89	3,023,334,909.68
2. Нэмэгдсэн	878,364,485.79	559,292,332.13
3. Хорогдсон	(670,000,000.00)	(26,718,593.46)
4. Эцсийн үлдэгдэл	3,023,334,909.68	3,555,908,648.35
Г. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		
1. Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(459,834,168.15)	638,210,063.78
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	596,670,100.00	-
3. Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(670,000,000.00)	-
4. Валютын ханшийн зөрүү	(1,994,163.74)	4,886.11
5. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(536,158,231.89)	638,214,949.89

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

2024 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

3

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	2023.12.31	2024.12.31
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4	63,370,958.40	701,585,908.29
Зээл	5	577,367,548.27	2,971,665,441.86
Факторингийн тооцооны авлага	-	-	-
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	-	-	-
Хөрөнгө оруулалт	-	-	-
Бусад санхүүгийн хөрөнгө	6	2,485,829,170.43	40,684,109.80
Санхүүгийн хөрөнгийн дүн		**3,126,567,677.10**	**3,713,935,459.95**
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ			
Татвар, НДШ-ийн авлага	-	-	-
Үндсэн хөрөнгө	7	6,342,041.52	15,499,048.79
Биет бус хөрөнгө	-	3,696,000.00	3,696,000.00
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-	-
Бусад санхүүгийн бус хөрөнгө	8	-	7,000,000.00
Санхүүгийн бус хөрөнгийн дүн		**10,038,041.52**	**26,195,048.79**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,136,605,718.62	3,740,130,508.74
ӨР ТӨЛБӨР			
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	-	-	-
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	-	-	-
Бусад эх үүсвэр	-	-	-
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	-	-	-
Бусад санхүүгийн өр төлбөр	9	-	101,469,724.22
Хоёрдогч өглөг	-	-	-
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-	-
Санхүүгийн өр төлбөрийн дүн	-	**-**	**101,469,724.22**
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР			
Татвар, НДШ-ийн өр төлбөр	10	18,932,665.48	82,752,136.17
Нөөц /Болзошгүй өр төлбөр /	-	-	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	-	-	-
Бусад санхүүгийн бус өр төлбөр	-	94,338,143.46	-
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн		**113,270,808.94**	**82,752,136.17**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		113,270,808.94	184,221,860.39
ӨМЧ			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	11	2,500,000,000.00	2,500,000,000.00
Өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-	523,334,909.68	1,055,908,648.35
Нийт өмчийн дүн		**3,032,334,909.68**	**3,555,908,648.35**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН		3,136,605,718.62	3,740,130,508.74

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	2023.12.31	2024.12.31
ХҮҮГИЙН ОРЛОГО			
Банканд байршуулсан хөрөнгийн	-	1,944,147.06	3,162,339.85
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	-	-	-
Зээлийн	-	768,627,901.89	710,989,671.88
Үнэт цаасны	-	-	-
Бусад	-	-	-
Хүүгийн орлогын буцаалт	-	(114,300,031.61)	(132,610,887.72)
Хүүгийн орлогын дүн		**884,872,080.56**	**581,541,124.01**
ХҮҮГИЙН ЗАРДАЛ			
Итгэлцлийн үр шим	-	-	-
Зээлийн	-	-	-
Үнэт цаасны	-	-	-
Бусад	-	37,229,447.87	-
Хүүгийн зардлын буцаалт	-	-	-
Хүүгийн зардлын дүн		**37,229,447.87**	**-**
ХҮҮГИЙН ЦЭВЭР ОРЛОГО		847,642,632.69	581,541,124.01
Эрсдэлийн сангийн зардал	-	(321,221,681.09)	(18,900,000.00)
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого		**526,420,951.60**	**562,641,124.01**
БУСАД ОРЛОГО	-	-	**340,144,978.31**
Хүүгийн бус орлого	*12*	-	340,144,978.31
Бусад орлого, олз	-	-	-
БУСАД ЗАРДАЛ	-	**219,112,678.93**	**278,979,789.07**
Хүүгийн бус зардал	*13*	219,095,031.83	268,296,664.07
Бусад зардал, гарз	*14*	17,647.10	10,683,125.00
Татварын өмнөх ашиг /алдагдал/		**307,308,272.67**	**623,806,313.25**
Орлогын татварын зардал		30,943,786.88	64,513,981.12
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ /АЛДАГДАЛ/		276,364,485.79	559,292,332.13
Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		**276,364,485.79**	**559,292,332.13**
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
ОРЛОГЫН НИЙТ ДҮН		276,364,485.79	559,292,332.13
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		-	-

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ	ХАЛААСНЫ ХУВЬЦАА	БУСАЛ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ)	НИЙТ ДҮН
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**1,900,000,000.00**	**-**	**-**	**-**	**914,970,423.89**	**2,814,970,423.89**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ	**1,900,000,000.00**	**-**	**-**	**-**	**914,970,423.89**	**2,814,970,423.89**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	600,000,000.00	-	-	-	278,364,485.79	**878,364,485.79**
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	(670,000,000.00)	**(670,000,000.00)**
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**2,500,000,000.00**	**-**	**-**	**-**	**523,334,909.68**	**3,023,334,909.68**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(26,718,593.46)	**(26,718,593.46)**
ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ	**2,500,000,000.00**	**-**	**-**	**-**	**523,334,909.68**	**3,023,334,909.68**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	559,292,332.13	**559,292,332.13**
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ҮЛДЭГДЭЛ	**2,500,000,000.00**	**-**	**-**	**-**	**1,055,908,648.35**	**3,555,908,648.35**

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	**2,878,750,521.32**	**3,293,350,531.23**
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	1,735,815,058.63	2,706,280,491.66
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	-	-
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хүлээн авсан	-	-
Факторингийн үйл ажиллагаанаас хүлээн авсан	-	-
Бусад мөнгөн орлого	1,142,935,462.69	587,070,039.57
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	**3,338,584,689.47**	**3,293,350,531.23**
Олгосон зээл	-	1,659,337,022.24
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	-	-
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн	-	-
Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн	-	-
Ажиллагсдад олгосон	93,703,105.97	108,193,250.00
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	21,419,241.92	69,595,126.60
Ашиглалтын зардалд төлсөн	16,541,036.98	14,434,200.00
Бусад мөнгөн зарлага	3,206,921,304.60	803,580,868.61
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(459,834,168.15)	638,210,063.78
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	**600,000,000.00**	-
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	600,000,000.00	-
Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	**4,329,900.00**	-
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад	4,329,900.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	596,670,100.00	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	-	-
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан	-	-
Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	**670,000,000.00**	-
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн	-	-
Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	670,000,000.00	-
Бусад	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(670,000,000.00)	-
Валютын ханшийн зөрүү	(1,994,163.74)	4,886.11
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(536,158,231.89)	638,214,949.89
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	63,370,958.40
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	63,370,958.40	701,585,908.29

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4

"Биг Могул ББСБ" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Биг Могул ББСБ" ХХК нь 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдөр үүсгэн байгуулагдсан ба зээл олгох үйл ажиллагаа явуулж байна. Хувьцаа эзэмшигч Б.Батмөнх нь 100 хувийн хувьцааг эзэмшдэг.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ ЗАРЧИМ

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС:

Компанийн санхүүгийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан А/286/528 дугаар тушаалаар "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгж, байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандартад нийцүүлэн бэлтгэсэн.

ҮНЭЛГЭЭ:

Санхүүгийн тайланд хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгийн зарчмаар хэмжиж бүртгэсэн. Зарим хөрөнгө, өр төлбөрүүдийг бодит үнэ цэнээр нь хэмждэг. Бодит үнэ цэн гэж хэмжилтийн өдөр зах зээлд оролцогчдын хоорондох ердийн ажил гүйлгээгээр хөрөнгийг шилжүүлснээр хүлээн авах, эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх дүнг хэлнэ. Бодит үнэ цэнийн хэмжилт, тодруулгын хувьд СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт-ийг мөрддөг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН ВАЛЮТ:

Компанийн ажил гүйлгээний хэмжих нэгж нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөг (MNT) юм. Санхүүгийн тайлангийн тодруулгад тоон үзүүлэлтүүдийг төгрөгөөр бэлтгэсэн.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУУРЬ:

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн аккруэль суурьт зарчимд үндэслэн бэлтгэдэг. Ингэхдээ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэль сууриар хөтөлнө" гэж заасныг мөрдлөг болгосон.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ТӨСӨӨЛӨЛ:

Компани нь ирээдүйд үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй бөгөөд цаашид хэвийн үргэлжлүүлэн явуулна гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэсэн. Компанийн удирдлага нь мөрдөж байгаа хууль эрх зүйн болон бизнесийн орчинд байгууллагын цаашдын үйл ажиллагаанд эрсдэл учруулахуйц тодорхойгүй үйл явдал байхгүй гэж үзсэн.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Анхдагч хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хөрөнгийг анх удаа түүний бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхдагч шууд зардлыг бодит үнэ цэнийн хэмжилт дээр нэмж тооцдог. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн анхдагч шууд зардал (гүйлгээний шимтгэл гэх мэт ажил гүйлгээний зардал)-ыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Ангилал

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө - Гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах зорилгоор эзэмшиж буй бизнесийн загвар бүхий санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд хамруулна. Гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болно. Зээл болон авлагууд нь идэвхитэй зах зээл дээрх жишиг үнэгүй, тогтмол

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд хамаарна. Дансны авлага нь үндсэн үйл ажиллагааны явцад зээлээр борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний төлөө худалдан авагч болон харилцагчаас авах мөнгөн дүн байна.

Дансны авлагыг анх СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүр-ийн 5.1.3-д заасны дагуу СТОУС 15 Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого-д заасан мэдэгдэхүйц санхүүжилтийн хэлэлцээр агуулаагүй бол ажил гүйлгээ үнээр хэмжинэ.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах болон мөн арилжих зорилгоор эзэмшиж байгаа бол эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана. Мөн гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болдог санхүүгийн хөрөнгө. Түүнчлэн тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөр болон тогтсон хугацаа байхгүй дунд болон урт хугацаанд эзэмшихээр шийдсэн хөрөнгө оруулалтыг энэ ангилалд багтаана.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө - Бодит үнэ цэнд үндэслэн гүйцэтгэлийг нь үнэлж, удирдан зохицуулдаг санхүүгийн хөрөнгийг дээр дурдсан 2 аргын шаардлага хангаагүй тохиолдолд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө гэж үзнэ. Өөрөөр хэлбэл тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн мэдээлэлд анхаарал хандуулдаг, тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг үнэлж, шийдвэр гаргахын тулд уг мэдээллийг ашигладаг, бизнесийн загварын хувьд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор ч эзэмшдэггүй, мөн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба борлуулах зорилгоор ч эзэмшдэггүй бол энэ аргын дагуу тухайн хөрөнгө оруулалтыг бүртгэнэ. Ийм санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээний мөнгөн гүйлгээний цуглуулалт нь тухайн бизнесийн загварын зорилгыг биелүүлэхэд зөвхөн тохиолдлын шинжтэй үйл явдал байдаг. Өөрөөр хэлбэл, арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан авч, богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай санхүүгийн хөрөнгө хамаарна. Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг энэ ангилалд хамааруулж ангилахгүй.

Дараа үеийн хэмжилт

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Тайлант үе бүрд үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Үр ашигт хүүний түвшнээр тооцсон хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Тайлант үе бүрийн эцэст бодит үнэ цэнээр нь санхүүгийн хөрөнгийг хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг дараах байдлаар толилуулна. Үүнд:

> *Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө* – Тайлант үеийн ашиг, алдагдлын бусад орлого эсвэл бусад зардлаар
>
> *Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө* – Үнэ цэнийн өөрчлөлтийг "бусад дэлгэрэнгүй орлого"-оор тус тус толилуулна.

Санхүүгийн хөрөнгө, түүний бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, олз, гарзыг тухайн тайлант хугацаанд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнийн тооцоолол

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг (олон нийтэд арилжигдсан дериватив болон арилжааны үнэт цаас гэх мэт) тайлант өдрийн арилжаа дуусах үеийн зах зээлийн ханшид үндэслэнэ. Идэвхтэй зах зээл дээр нийтлэгдсэн үнийн саналууд байгаа нь бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бөгөөд хэрэв байгаа бол тэдгээрийг бодит үнэ цэнийг

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

хэмжихэд ашигладаг. "Идэвхтэй зах зээл дээр үнэлэгдсэн" гэсэн хэллэг нь бирж, дилер, брокер, салбарын бүлэг, үнийн үйлчилгээ эсвэл зохицуулах агентлагаас санал болгож буй үнийг бэлэн бөгөөд тогтмол авах боломжтой гэсэн үг юм. Эдгээр үнэ нь зах зээлийн бодит ба тогтмол гүйлгээг илэрхийлдэг бөгөөд энэ нь хүндрэлтэй борлуулалт биш юм. Үнийг үндсэн зах зээлээс эсвэл үндсэн зах зээл байхгүй тохиолдолд хамгийн ашигтай зах зээлээс авч болно [СТОУС13(16)]. Зах зээлийн үнийг гүйлгээний зардалд тохируулах боломжгүй [СТОУС13(25). Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо дараах түвшнийг хэрэглэнэ.

Үүнд:

- I түвшин – Идэвхтэй зах зээл дээрх үнэ. Тухайлбал: арилжаа солилцооны зах зээл, дилер, брокер, оролцогчдын хоорондын зах зээл.
- II түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг шууд ба шууд бусаар үзүүлэх мэдээлэл. Тухайлбал: LIBOR ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп, тодорхой банкны суурь ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп.
- III түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг үзүүлэх зах зээл дээр ажиглагддаг мэдээллийг ашиглах бусад аргачлалууд

Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Үүнд:

- Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан, эсвэл
- Уг эрхээ бусдад шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийн эрсдэл өгөөж бүрэн шилжсэн эсвэл бүх эрсдэл өгөөжийг шилжүүлээгүй боловч захиран зарцуулах эрхийг нь шилжүүлсэн бол.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийг худалдан борлуулсан бол бусад дэлгэрэнгүй орлогоор өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн хэрэгжээгүй бодит үнэ цэнийн хуримтлагдсан дүнг тайлант үеийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдал (зээлийн чанар сайжирсан г.м)-тэй холбоотойгоор үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсны илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө нь хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүнээс хуримтлагдсан алдагдлаар өмчийг бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

бууралтын алдагдлыг дараагийн хугацааны туршид ашиг алдагдал руу буцаахгүй. Бодит үнэ цэнийн хэмжилтийг өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэн өсөлт эсвэл бууралт дараагийн үеүдэд өссөн эсвэл буурсан бол уг өсөлт, бууралтыг өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралтын нэгэн адил бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалтаар банк, санхүүгийн байгууллага дахь харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгүүдээс бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

ЗЭЭЛ

Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжих ба хэрэв зээл олгохтой шууд холбоотой ажил гүйлгээний зардал гарсан бол уг зардлыг бодит үнэ цэнэ дүн дээр нэмэх эсвэл хасах байдлаар хэмжинэ. Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна.

ЗЭЭЛИЙН ЭРСДЛИЙН САН

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу сар бүр зээлийн эрсдэлийн санг байгуулна. Түүнчлэн тайлант жилийн эцэст зээлийн үнэ цэнийн бууралтыг СТОУС-9-д нийцүүлэн тооцож болно. СТОУС 9-д заасан үнэ цэнийн бууралтын загвар нь хүлээгдэж буй алдагдлын загвар бөгөөд алдагдал үүсэх үйл явдал тохиолдохоос өмнө үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрдөг. Зээлийн эрсдэлийн сангийн зардал (үнэ цэнийн бууралт)-ыг тооцохдоо Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ыг баримтална.

Санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дараах дүнгээр хүлээн зөвшөөрнө:

- санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдээгүй тохиолдолд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр;
- санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн тохиолдолд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр.

Тайлагналын өдрөөр зээлийн үнэлэмж буурсан бол ТЗЭ нь тухайн хөрөнгийн эрсдэлийн санг хасаагүй хорогдуулсан өртөг ба анхны үр ашигт хүүгийн түвшнээр дискаунтчилж тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн хоорондын зөрүүгээр хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжинэ. Түүнд хийх аливаа тохируулгыг эрсдэлийн сангийн зардал эсвэл бусад орлогоор хүлээн зөвшөөрнө.

ГАДААД ВАЛЮТЫН БҮРТГЭЛ

Санхүүгийн тайланг Монгол төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт - Монгол төгрөг (MNT) юм. Гадаад улс орны валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр, гүйлгээг тайлан гаргасан өдрийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж санхүүгийн тайланд тусгана.

Хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүг гадаад валютын олз гарзаар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэлд тусгана.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

САНХҮҮГИЙН ТҮРЭЭС

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор эрх олгосон тохиолдолд санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг эрхэлж болно. Санхүүгийн түрээсийг хүлээн зөвшөөрч бүртгэхдээ СТОУС 16-г дагаж мөрдөнө.

ФАКТОРИНГИЙН ТООЦООНЫ АВЛАГА

Факторингийн үйл ажиллагаанд санхүүгийн өр төлбөрийг хүлээн авахад холбогдох эрсдэл, өгөөжийг бүгдийг хүлээн авах эсэхийг тогтоох ба шаардах эрхийг бүрэн хүлээн авсан бол уг санхүүгийн хэрэгслийг холбогдох дансанд бүртгэнэ. Харин эрсдэл өгөөжийг бүрэн хүлээн аваагүй бол хүлээн авсан хяналтын хэмжээгээр бүртгэнэ.

ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээгээр орлого хүлээн зөвшөөрсөн тохиолдолд үүсмэл санхүүгийн хөрөнгө, зардал хүлээн зөвшөөрсөн үед үүсмэл санхүүгийн өглөгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээний өөрчлөлтийн олз, гарзыг санхүүгийн тайланд цэвэр дүнгээр толилуулах ба мөн үүний нэгэн адил арилжааны орлого, зардлыг цэвэр дүнгээр тайлагнана. .Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь үнэлэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлаар бүртгэнэ. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эерэг утгатай гарвал санхүүгийн хөрөнгө, сөрөг утгатай гарвал санхүүгийн өр төлбөр үүснэ.

БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Бусад санхүүгийн хөрөнгө гэж бусад аж ахуйн нэгжээс мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрхийг хэлнэ. Хэрэв мөнгө болон санхүүгийн бусад хөрөнгийг авах гэрээний эрх үүсээгүй тохиолдолд уг хөрөнгийг бусад санхүүгийн бус хөрөнгө гэж үзнэ. Зээлээс бусад тооцооны авлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага, салбар хоорондын тооцоо, өмчлөх бусад хөрөнгө (зээлдэгчээс зээлийн төлбөрт авсан үнэт цаас гэх мэт санхүүгийн хөрөнгө), бусад санхүүгийн хөрөнгийг хамруулна.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

Санхүүгийн бус хөрөнгөд урьдчилж төлсөн зардал, тооцоо, бараа материал, үнэ бүхий зүйлс, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, тайлант үеийн татварын авлага, хойшлогдсон татварын хөрөнгө, өмчлөх бусад хөрөнгө (хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө), үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө зэрэг хамаарна.

УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТООЦОО

Хөрөнгийг худалдан авч, олж бэлтгэхтэй холбоотой урьдчилгаа төлбөр болон томилолтын зардлыг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэнэ. Хөрөнгийг хүлээж авсан, томилолтын тооцоог хийсэн үед урьдчилгаа тооцоог хааж, холбогдох хөрөнгө эсхүл зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ

Өмчлөх бусад хөрөнгийг холбогдох зээл, хуримтлуулсан хүүгийн авлагын нийт дүн ба (барьцаат хөрөнгийг борлуулаад орох орлогыг зээлийн дүнгээр хязгаарласан нөхцөлд) уг хөрөнгийн тухайн үеийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар нь анх үнэлж, бүртгэнэ. Зээл, түүнд хамаарах авлагын (хүү ба шимтгэл) дүн нь өмчлөх бусад хөрөнгийн зах зээлийн үнээс их байгаа тохиолдолд өмчлөх бусад хөрөнгийг бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгээр бүртгэж, зээл, түүнд хамаарах авлагын дүнг мөн энэ хэмжээ хүртэл бууруулна. Эдгээрийн зөрүүг өмчлөх бусад хөрөнгийн зардалд бүртгэж, орлогын тайланд толилуулна.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт,хүлээн зөвшөөрөх нөхцөлийн дагуу, анхны өртгөөр хэмжиж үнэлэн зохих ангиллын дансанд бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь хөнгөлөлт ба үнийн бууралтыг хассан үнэ, импортын татвар ба буцаан үл олгогдох худалдан авалтын татвар, хөрөнгийг ашиглах боломжтой байршил болон нөхцөл байдалд авчрахтай шууд хамааралтай зардал, үндсэн хөрөнгийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах тооцоолсон зардал зэргээс бүрдэнэ. Үндсэн хөрөнгийг өртгийн загвар ба дахин үнэлгээний загварын аль нэгээр бүртгэнэ. Өртгийн загвар нь хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнийн цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд толилуулна. Дахин үнэлгээний загвар нь хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээс хуримтлагдсан элэгдэл, үнийн цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд толилуулна.

БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анхны удаад өртгөөр хэмжинэ. Түүнд шууд хамааралтай ажил гүйлгээний зардлыг хөрөнгийн өртөгт оруулна. Худалдан авсан хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн өртөгт худалдан авсан үнэ, бусад шууд холбоотой зардал багтана. Шууд холбоотой зардалд хуулийн үйлчилгээний төлбөр, хөрөнгийг шилжүүлэхэд төлөх татвар, бусад зардал хамаарна. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг дансны үнэ ба борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар хэмжиж, тайлагнана. Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнд элэгдэл тооцохгүй.

САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

Ангилал

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

- *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*
- *Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр - Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүл эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

Бусад санхүүгийн өр төлбөр - Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүний зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү,эсвэл купон багтана. Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүний түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР

Санхүүгийн тайланд итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр үнэлж, тайлагнана. Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн хорогдуулсан өртөг нь анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүн дээр тайлант хугацаанд нэмэгдсэн итгэлцлийн үйлчилгээний орлого, итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд тооцсон үр шимийн өглөгийг нэмж, тайлант хугацаанд хийсэн зарлагын гүйлгээ, холбогдох шимтгэлийг хасаж тодорхойлогдоно.

БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР

Санхүүгийн тайланд бусад банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэрийг хорогдуулсан өртгөөр үнэлж, тайлагнана. Эх үүсвэрийн хорогдуулсан өртгийг зээлийн анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөр ба хойшлогдсон зардлын үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасаж тодорхойлно. Үр ашигт хүүгийн түвшинг тооцохдоо тухайн санхүүгийн хэрэгслийн гэрээний бүх нөхцөлийг харгалзан үзэж, мөнгөн гүйлгээг үнэлнэ. Энэ тооцоололд үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон гэрээний талуудын хооронд төлөгдөх бүх хураамж, шимтгэл, бусад бүх урамшуулал, хямдруулалтыг багтаана.

БУСАД ЭХ ҮҮСВЭР

Бусад эх үүсвэрт харилцагчид, банк, санхүүгийн байгууллагаас бусад зээлдүүлэгчдээс тодорхой зориулалт, нөхцөлтэй байршуулсан эх үүсвэр болон төлбөр тооцооны бусад хэрэгслийн эх үүсвэр болгон ашиглахаар байршуулсан зээлдүүлэгчээс авсан төслийн зээлийн санхүүжилт, гаргасан өрийн бичиг, үнэт цаас баталгаа, батлан даалтын барьцаа, хөрвөх эрхтэй зээлийн өр төлбөр болох хэсэг хамрагдана. Төслийн зээлийн эх үүсвэрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Төслийн зээлийн эх үүсвэрт төлөх хүүг гэрээнд заасан хувь хэмжээгээр, өдөр бүр хуримтлуулан тооцож тухайн тайлант хугацааны зардалд бүртгэнэ.

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Өрийн бичгийг анхны удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээс шууд холбогдох зардлыг хассан дүнгээр үнэлнэ. Санхүүгийн өр төлбөрийн хувьд (гаргасан бонд ба бусад үнэт цаас) ажил гүйлгээний өртгийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хасна. Энэ нь уг үнэт цаасыг гаргаад татан төвлөрүүлсэн цэвэр мөнгөн дүнгээр илэрхийлэгдэнэ.

Өрийн бичгийг хорогдуулсан өртгөөр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна. Хорогдуулсан өртгийг тодорхойлохдоо анхны үнээс үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулалтыг хасах буюу хямдруулалтын хорогдуулалтыг нэмнэ.

ХОЁРДОГЧ ӨГЛӨГ

Хоёрдогч өглөгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр хэмжиж, дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжиж, санхүүгийн тайланд толилуулна. Мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөр бүхий ажил гүйлгээгээр үйлчилгээг үзүүлсэн даруйд өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Өр төлбөрийг барагдуулах хүртэл тайлант хугацаа бүрийн эцэст болон төлбөр барагдуулах өдрөөр өр төлбөрийг бодит үнэ цэнээр үнэлж, үнэлгээнд гарсан өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.

САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР

Санхүүгийн бус өр төлбөрт цалингийн өглөг, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, тайлант үеийн орлогын албан татварын өглөг, бусад татварын өглөг, хойшлогдсон татварын өглөг, хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөц, зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүргийн нөөц, хойшлогдсон орлого, урьдчилж орсон орлого, борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр, тэтгэвэр, тэтгэмжийн сан (өр төлбөр), түрээсийн хойшлогдсон орлого хамрагдана.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулиар хүлээсэн болон гэрээний бус одоогийн үүрэгтэй, дүнг нь найдвартай тооцох боломжтой бөгөөд уг үүргийг барагдуулахад хөрөнгө зарцуулах магадлалтай үед нөөцийг хүлээн зөвшөөрнө.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Өмч нь хувь нийлүүлсэн хөрөнгө, нэмж төлөгдсөн капитал, халаасны хувьцаа, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хуримтлагдсан ашиг, алдагдал, бусад өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.

ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ

Өмчийн бусад хэсэг (бусад өөрийн хөрөнгө) нь нөөцийн сан, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц, эрсдэлийн сангийн нөөц, нийгмийн хөгжлийн сан, хувьцаанд хөрвөх үнэт цаас, хувьцаанд хөрвөх эх үүсвэр, бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны дахин үнэлгээний сан, хейжийн хэрэгслийн дахин үнэлгээний сан зэргээс бүрдэнэ.

ОРЛОГО

Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшинг ашиглан тооцож, үнэлнэ. Гэрээний дагуу нэмэлт төлбөр, хойшлогдсон орлого, зардал гараагүй нөхцөлд хүүгийн орлогыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ. Хямдруулалт, урамшуулал, хойшлуулсан орлого, зардлыг холбогдох санхүүгийн хэрэгслийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хуваарилж, бүртгэнэ.

ЗАРДАЛ

Хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшнээр тооцож үнэлнэ. Татан төвлөрүүлсэн эх үүсвэртэй холбоотой нэмэлт урамшуулал, хямдруулалт, хойшлогдсон орлого болон зардал гараагүй нөхцөлд хүүгийн зардлыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ.

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу компани санхүүгийн жилийн татварногдуулах орлого, түүнд ногдуулсан орлогын албан татварыг тодорхойлж тайлагнана. Энэ хуулиар компанинь 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдох орлогод 10 хувь, 6 тэрбум төгрөгөөс давсан татвар ногдох орлогод 25 хувийн татвар тооцож төлдөг.

ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС

Тэнцлийн гадуурх данс нь зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг, болзошгүй үүрэг, барьцаа хөрөнгө, тэнцлээс хассан хөрөнгө, үүсмэл санхүүгийн хэрэглүүр, барьцаанд тавьсан хөрөнгө зэрэг үйл ажиллагааг бүртгэх данс юм.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
4. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		
Бэлэн мөнгө	3,166,559.10	1,412,124.15
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө		
Дотоодын банканд байршуулсан мөнгө	60,204,339.30	700,173,784.14
Гадаадын банканд байршуулсан мөнгө	-	-
ДҮН	63,370,958.40	701,585,908.29

Тайлбар: Компанийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө болон харилцах дансуудаас бүрдэж байна. Валютын дансны үлдэгдлийг Монгол Банкны хаалтын ханшаар хөрвүүлэн толилуулсан.

ҮЗҮҮЛЭЛТ **5. ЗЭЭЛ**	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ОЛГОСОН/ НЭМЖ БАЙГУУЛСАН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
Хэвийн /байгууллага/	622,500,000.00	-	282,500,000.00	340,000,000.00
Хэвийн /Хувийн сектор/	100,000,000.00	380,873,248.88	180,873,248.88	300,000,000.00
Хэвийн /Иргэд/	1,753,329,170.43	1,713,261,308.29	1,715,848,241.63	1,750,742,237.09
Хэвийн /Гадаадын оршин суугч/	-	4,512,500.00	645,011.15	3,867,488.85
Муу /Хувийн сектор/	9,985,907.04	-	9,985,907.04	-
Муу / Иргэд/	311,235,774.05	-	303,235,774.05	8,000,000.00
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	511,657,547.47	602,561,613.51	537,163,445.06	577,055,715.92
Хасах нь: Зээлийн эрсдэлийн сан	(321,221,681.09)	-	313,221,681.09	(8,000,000.00)
ДҮН	2,987,486,717.90	2,701,208,670.68	3,343,473,308.90	2,971,665,441.86

Тайлбар: Зээл, зээлийн эрсдэлийн санг "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу бүртгэсэн. Компанийн өмнөх оны санхүүгийн тайлан, тодруулгууд нь аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгын загвараар тайлагнагдсан ба зээл дансанд дансны авлагыг толилуулсан байсан. Тайлант оноос Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан А/226/528 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор уг ангиллын алдааг журмын дагуу залруулсан болно.

ҮЗҮҮЛЭЛТ **6. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
Хэвийн авлага	2,200,000.00	1,114,869.00	2,200,000.00	1,114,869.00
Бусад	63,510,000.80	677,237,796.55	682,278,556.55	58,469,240.80
Хасах нь: Авлагын эрсдэлийн сан	-	(18,900,000.00)	-	(18,900,000.00)
ДҮН	65,710,000.80	659,452,665.55	684,478,556.55	40,684,109.80

Тайлбар: Тайлант онд "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу 121-с дээш хоног төлөгдөөгүй буюу муу ангиллын авлагад эрсдэлийн сан байгуулсан. Бусад авлагад хувь хүнээс авах авлагуудыг хуримтлуулан бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ **7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
Үндсэн хөрөнгө	21,080,238.54	15,943,226.54	4,495,613.27	32,527,851.81
ДҮН	21,080,238.54	15,943,226.54	4,495,613.27	32,527,851.81

Тайлбар: Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр хэмждэг ба хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг, хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрддэг. Үндсэн хөрөнгө ашиглагдах хугацаандаа өртгөө нөхөхөөр тооцож шулуун шугамын аргаар элэгдлийг байгуулж орлогын дэлгэрэнгүй тайланд тусгадаг.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

ҮЗҮҮЛЭЛТ **ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ**	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
Үндсэн хөрөнгө	14,738,197.02	6,786,219.27	4,495,613.27	17,028,803.02
ДҮН	14,738,197.02	6,786,219.27	4,495,613.27	17,028,803.02

ЗҮҮЛЭЛТ **8. БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ**	2023.12.31	2024.12.31
Урьдчилж төлсөн тооцоо/ зардал	-	7,000,000.00
ДҮН	-	7,000,000.00

ҮЗҮҮЛЭЛТ **9. БУСАД САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР**	2023.12.31	2024.12.31
Бусад	-	101,469,724.22
ДҮН	-	101,469,724.22

Тайлбар: Бусад санхүүгийн өр төлбөрт байгууллага болон хувь хүмүүст өгөх өглөгийг хуримтлуулан бүртгэсэн. Уг дансны өглөгийг гуравдагч талын тулган баталгаажуулалтаар баталгаажуулсан болно.

ҮЗҮҮЛЭЛТ **10. ТАТВАР, НДШ-ИЙН ӨР ТӨЛБӨР**	2023.12.31	2024.12.31
ХХОАТ-ын өглөг	13,845,283.28	74,904,991.54
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	5,087,382.20	7,847,144.63
ДҮН	18,932,665.48	82,752,136.17

ҮЗҮҮЛЭЛТ **11. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ**	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
Энгийн хувьцаа	2,500,000,000.00	-	-	2,500,000,000.00
ДҮН	2,500,000,000.00	-	-	2,500,000,000.00

ҮЗҮҮЛЭЛТ **12. ХҮҮГИЙН БУС ОРЛОГО**	2023.12.31	2024.12.31
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз	-	4,886.11
Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого		
Зээл, хураамж шимтгэлийн орлого	-	15,442,554.47
Бусад орлого	-	324,697,537.73
ДҮН	-	340,144,978.31

Тайлбар: Зээл хураамж шимтгэлийн орлогод зээл олгохтой холбоотой шимтгэлийн орлогуудыг бүртгэсэн. Бусад орлогод эрсдэлийн сангаас төлөгдсөн зээлийн орлогыг бүртгэсэн.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
13. ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ		
Үйлчилгээний хураамж шимтгэлийн зардал	-	2,782,468.54
Удирдлага ба үйл ажилллагааны бусад зардал	219,095,031.83	265,514,195.53
ДҮН	219,095,031.83	268,296,664.07

Тайлбар: Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардалд ажилчдын цалин 131,734.1 мянган төгрөг, НДШ-ийн зардал 16,301.6 мянган төгрөг, зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой зардал 16,177.8 мянган төгрөг, түрээсийн зардал 58,057.6 мянган төгрөг, бусад зардал 15,094.7 мянган төгрөг гэх мэт компанийн үндсэн үйл ажиллгаатай холбоотой урсгал зардлуудыг хуримтлуулан бүртгэсэн.

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
14. БУСАД ЗАРДАЛ, ГАРЗ		
Зочин төлөөлөгчийн зардал	-	6,747,000.00
Баяр ёслол	-	2,769,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны бусад зардал	17,647.10	1,167,125.00
ДҮН	17,647.10	10,683,125.00

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
15. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС		
Барьцаа хөрөнгө	-	26,963,225,000.00
ДҮН	-	26,963,225,000.00

Тайлбар: Барьцаат зээлтэй холбоотой автомашин, үл хөдлөх хөрөнгө гэх барьцааныудыг "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн.

БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Энэхүү тайланг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр бэлтгэсэн. Тасалбар болгосноос хойш тайланд нөлөөлөх /залруулагдах/ үйл явдал гараагүй болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30

“ИНТЕР АУДИТ” ХХК

Аудитын компанийн хаяг:
Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр 802 тоот

Холбогдох:

Утас: 99004839

Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.01.30